

ЛЕКЦ, ТОЙМ, ЗӨВЛӨГӨӨ

ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ АЖЛЫГ СЭРГЭЭЖ, ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Б.Оргил

“Ач” Анагаах ухааны их сургууль

Email: naranzaya@ach.edu.mn

1990-ээд онд ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн байгууллагаас боловсруулан гаргасан “Эрүүл мэндийн шинэ төлөв” (New horizon in health) хэмээх баримт бичигт эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийг дэмжих үзэл баримтлалыг анх дэвшүүлсэн. “Эрүүл мэндийн шинэ төлөв” хэмээх шинэ бодлогын гол үзэл баримтлал нь хүн төвтэй, хүний эрүүл мэндийг хамгаалан дэмжих, хүнийг хөгжүүлэхэд чиглэгдсэн хандлагаар илэрдэг бөгөөд ингэхдээ хүний амьдралын үндсэн 3 үе болох: хүүхэд, залуу насанд амьдралд бэлтгэх; идэр насанд амьдралыг нь хамгаалах; өтөл насанд амьдралын чанарыг нь хангах явдал мөн хэмээн үзэж байсан [4].

Улмаар уг баримт бичигт (4): “*Эрүүл мэндийг хамгаалах гэдэг нь хүний амьдралын мөнх бусыг хүлээн зөвшөөрч, эрүүл мэндийн асуудлаар хүний ойлгож мэдэх, сурч боловсрох үйлст шинжлэх ухааны дэвшил болон бусад мэдээллийн тус нэмэр болж чадах бүхнээр хүний эрэлт хэрэгцээг хангахыг хэлнэ*”; “*Хүн өөрийгөө хянан жолоодож, эрүүл мэндээ сайжруулахын төлөө гэр бүл, хамт олон, үндэстэн түмэнтэйгээ хамтран, өөрсдөө хийж чадах зүйлийг улам нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх зан үйлийг дэмжин урамшуулахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг эрүүл мэндийг дэмжих гэнэ*” хэмээн тус тус томъёолсон байв. Тэгээд эрүүл мэндийг дэмжих (ЭМД) үйл ажиллагааны зорилгыг дараахь байдлаар тодорхойлсон байдаг.

Үүнд:

1. Хувь хүмүүсийн амьдралынх нь бүх шатанд хаяаагүй тэдний эрүүл мэндийг гэр бүлийнхэн нь ажил, сургуулийн хамт олон нь дэмжих чиглэлийн үйл ажиллагаа явуулж, улмаар тэдний чадварыг дээшлүүлэх;
2. Эрүүл ба архаг өвчтэй хүмүүст эрүүл мэндийн нөөц бололцоогоо аль болох бүрэн дүүрэн нээж илрүүлэх боломж олгох;
3. Хүмүүст өөрсдийнхөө эрүүл мэндэд хяналт тавих эрх мэдлийг шилжүүлэх ба түүнийг боловсронгуй болгох;

4. Хүрээлэн буй орчноо өөрчлөх, өөрсдийнхөө хэрэгцээг хангахын тулд хүсэл эрмэлзлэлээ тодорхойлох ба хангах хувь хүний, хамт олны чадварыг хөгжүүлэх;

Чухамхүү ЭМД үйл ажиллагааны мөн чанар нь эрүүл мэндэд аюул учруулахгүй арга замыг олон ба хувь хүмүүс, нийгмийн бүлэг хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн мэдлэг, дадлагыг олгодог үргэлжилсэн үйл ажиллагаа юм. Мөн ЭМД нь хүмүүсийн эрүүл байх эрмэлзлэл, оролдлогыг дэмжсэн орчныг бий болгоход чиглэгддэг. Ер нь эрүүл мэнд нь хувь хүн, хамт олны аль альных нь амдралын чанарыг дээшлүүлэгч чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хүний эрүүл мэнд сайн байх нь амьдралын чанар сайн байхын нэг үндэс мөн [1].

ЭМД үйл ажиллагаанд дараахь зарчмуудыг баримталдаг: 1) ЭМД үйл ажиллагаа нь өвчтэй тодорхой хүнд хандахаасаа илүүтэй нийт хүн амын өдөр тутмын амьдралд чиглэсэн байх; 2) ЭМД үйл ажиллагаа нь эрүүл мэндийг тодорхойлогч хүчин зүйлст чиглэсэн байх; 3) ЭМСалбараас гадна, хүний эрүүл мэнд, амьдралын нөхцөлд нөлөө бүхий бусад салбар хоорондын нягт хамтын ажиллагаанд тулгуурлах; 4) ЭМД нь янз бүрийн арга, хандлагуудыг, тухайлбал харилцаа холбоо, боловсрол, хууль тогтоомж, бүтцийн өөрчлөлт, хамт олны хөгжил болон эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хүчин зүйлийн эсрэг авах шуурхай арга хэмжээ зэргийг хослуулан хэрэглэдэг байх; 5) ЭМД үйл ажиллагаа нь хамт олны оролцоонд тулгуурлахын зэрэгцээ тулгамдсан асуудлыг тодорхойлж, шийдвэр гаргах хувь хүний ба хамт олны чадварыг хөгжүүлэх, хамтын оролцооны үр дүнтэй механизмыг ашиглах; 6) Хэдийгээр ЭМД үйл ажиллагаанд ЭМАжилтнууд чухал үүрэг гүйцэтгэх боловч энэ нь эмнэлгийн үйлчилгээ биш, харин нийгэм, улс төрийн мөн чанар бүхий үйл ажиллагаа юм гэдэг зарчмаар хандах [1, 4].

Манай улс ЭМД талаархи тэрхүү үзэл баримтлалыг дуртайяа хүлээн авч, эрүүл мэндийг дэмжих (health promotion) хөдөлгөөнийг нилээд өргөн хүрээнд өрнүүлж байсан билээ. Тухайлбал, 1990-ээд оны сүүлчээс “Эрүүл

мэндийг дэмжигч сургууль”, “Эрүүл мэндийг дэмжигч эмнэлэг”, “Эрүүл мэндийг дэмжигч үйлдвэр”, улмаар “Эрүүл мэндийг дэмжигч хот”-ын төлөө хөдөлгөөнийг өрнүүлж, багагүй амжилт олж байлаа. Бидний ажиглалт судалгаагаар, 1995 оноос Улаанбаатар, Дархан хотууд эрүүл мэндийг дэмжигч хот болох зорилт тавин ажиллаж байсан. Манай улсын хот, хөдөөд ЭМД-гч сургуулийн хөдөлгөөн өрнөж, 2003 оны байдлаар нийслэлийн 2, 17, 58-р сургууль, Булган аймгийн төвийн 2-р сургууль, Хишиг-Өндөр сумын сургууль, мөн Дархан-Уул аймгийн зарим сургууль “ЭМД-гч загвар сургууль” болох зорилт тавин ажиллаж байв. Нийтдээ 45 сургууль ийм зорилттой ажиллаж байлаа. Мөн 1998 оноос П.Н.Шастины нэрэмжит клиникийн нэгдсэн 3-р эмнэлэг “ЭМД-гч эмнэлэг” болох санаачлага гарган ажиллаж байв. 1998 оноос нийслэлийн “Махимпекс” ХХК, Дулааны 2,4-р цахилгаан станц, “Атар өргөө”, “Улаанбаатар хивс”, Бетон завод зэрэг цөөнгүй үйлдвэр, аж ахуйн газрууд “ЭМД-гч үйлдвэр” болох хөтөлбөр гарган хэрэгжүүлж байсан [2, 3].

Гэтэл харамсалтай нь, 2010-аад оноос хойш манай улсад хааяагүй “Эрүүл мэндийг дэмжих” хөдөлгөөн намжиж, чимээгүй болсоор, улмаар замхрах байдалд орчихоод байна. Хэдийгээр нэлээд оройтсон ч гэсэн, энэхүү асуудалд зохих ёсоор анхаарал хандуулж, ЭМД үзэл бодол, үйл ажиллагааг сэргээж, улмаар өргөжүүлэн хөгжүүлэх арга замыг тодорхойлж, ажил хэрэг болгомоор байна.

Гадаадын олон улс оронд баримтлан, мөрдөж байгаа зарчмаар бол ЭМД-д Засгийн газар, төрийн байгууллагын үүрэг үлэмж их юм. Ялангуяа энэ асуудлыг манай ЭМЯ голлон анхаарч, ЭМД үйл ажиллагааг улсын хэмжээнд ЭМЯ; орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн ЭМГ тууштай зохицуулан явуулдаг болмоор байна. ЭМЯ, аймаг, нийслэлийн ЭМГ-ууд нь эрүүл мэндийн нийт байгууллагуудаас гадна, бусад салбарын байгууллага, аж ахуйн нэгжүүдийг ЭМД үйл ажиллагаанд уриалан манлайлж, тэдэнд аргазүйн тодорхой зөвлөгөө өгч, хамтран ажилламаар байна.

Ялангуяа ЭМЯ-аас санаачилж, ЭМД үйл ажиллагааны зорилго, зарчим, арга барил, ач холбогдлын талаар эрүүл мэндийн салбарын хүрээнд тодорхой хөтөлбөр бүхий зөвлөлгөөн, семинар, сургалтын төв, хөдөөд системтэй зохион байгуулж, түүндээ эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтнүүдийг өргөн хамруулуштай. Мэдээж, ЭМД талаархи ДЭМБ-

ийн бодлого, зөвлөмжүүд болон гадаадын улс орнуудын туршлагаас манай ЭМЯ зориуд тодорхой судалж, өөрийн орондоо тууштай нэвтрүүлэх нь маш чухал болно.

ЭМД үйл ажиллагаа нь зөвхөн эрүүл мэндийн байгууллагуудын төдийгүй, бусад салбаруудын байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, хувь хүний хүчин чармайлт, идэвхитэй оролцоог шаарддаг болохыг нийт байгууллага, аж ахуйн нэгжүүдэд болон ард иргэдэд сайтар ойлгуулахад чиглэгдсэн ажлыг өргөн хүрээнд зохион байгуулж, өрнүүлмээр байна.

ЭМД үйл ажиллагаа нь тухайн орон нутагт бол, дэвсгэр нутгийн төр, захиргааны байгууллага, иргэд хамт олны оролцоотойгоор л үр дүнд хүрэх болно гэдгийг нийслэлийн дүүрэг, хорооны удирдлагад болон аймаг, сум, багийн дарга нарт нэлээд сайтар ойлгуулах нь чухал билээ.

Юуны түрүүнд урьд өмнө нь ЭМД хөдөлгөөнд идэвхитэй хамрагдаж байсан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хандаж, ЭМД-д чиглэгдсэн уг үйл ажиллагаагаа ойрын үед сэргээн өрнүүлэхийг уриалан дуудууштай. Улмаар ЭМД талаар сайн ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжийн туршлагыг бусад байгууллага, аж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлэх ажлыг дэмжин явуулуштай.

Тэгээд ЭМЯ-ны зүгээс ЭМД ажлын үр дүнг жил бүр улсын хэмжээнд нэгтгэн гаргаж, ЭМД талаар тэргүүлэгч байгууллага, аж ахуйн нэгжүүдийг шалгаруулж, шагнаж урамшуулдаг байгууштай. Ингэснээр ЭМД хөдөлгөөн улс даяар өрнөж, цаашдын үр дүнгээ өгсөөр байх бизээ.

Ашигласан ном зүй

1. Женний Найдүү, Жейн Виллс. Эрүүл мэндийг дэмжих нь. УБ., 2006
2. Оргил Б., Баярцэцэг Ц., Гүндэгмаа Ц., Жаргал Т. Нийгмийн эрүүл мэнд судлал. 2 дахь хэвлэл. Редактор О. Чимэдсүрэн. УБ., 2017
3. Эрүүл мэндийг дэмжих арга хэмжээнд хамт олныг оролцуулах нь. Сургалтын гарын авлага. ЭМЯ, АХБ, “ЭМСХХ-3” Төсөл. УБ., 2011
4. New horizon in health. The WHO Regional Office for the South-East Asia. New Delhy, 1995